



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 1/127

Батширээт сум

**Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1, 69.1.2, 69.1.3, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/350 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан 2025 оны 06 дугаар сарын 20-ноос 2025 оны 06 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд сумын хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг, 2025 оны 06 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд спорт, соёл урлаг, үзвэр үйлчилгээ зэрэг олон нийтийг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулахыг хориглосугай.

2. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангаж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хэсгийн Төлөөлөгч, Цагдаагийн ахлах дэслэгч (Р.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Норовлин багийн Засаг дарга (Б.Бадамгарав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Б.ТӨРМӨНХ

23.06.2025